



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/528

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай XIX/08 тогтоол, аймгийн Засаг даргын "Шинэ хөжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Алтаргана-2024" Олон Улсын XV их наадмаар хүндэт зочдын 200 хүний хүлээн авалтын катеринг үйлчилгээ үзүүлэх компаниар "Чин гурав" ХХК-ийг сонгож 49.650.000 /Дөчин есэн сая зургаан зуун тавин мянга/ төгрөгийн гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг Даргын Тамгын газрын дарга /Д.Алтаншагай/-д олгосугай.

2. Хяналт тавьж ажиллахыг Стандарт хэмжилзүйн газрын дарга /Ц.Бүрэнтуяа/-д үүрэг болгосугай.

3. Дээрх шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг Даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас санхүүжүүлэхийг АЗДТГ-ын дарга /Д.Алтаншагай/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010891